

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ТАВИХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү нөхцөл, шаардлагын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оос хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага болон Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоонд тавих шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих болон холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү нөхцөл, шаардлага нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

ХОЁР. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ШААРДЛАГА

2.1. ХЗХ нь үйл ажиллагаандаа хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж дараах шаардлагыг хангана:

2.1.1. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтлах;

2.1.2. Бүх гишүүдийн ээлжит хурлыг хуулийн хугацаанд зарлан хуралдуулж Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан бүх гишүүдийн хурлын бүрэн эрхийн асуудлуудыг бүрэн хэлэлцүүлж, холбогдох шийдвэрүүдийг гаргах, хуралдааны тэмдэглэлийг хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу хөтөлж хурал хуралдсанаас хойш 30 хоногийн дотор Хороонд хүргүүлэх;

2.1.3. Хорооноос тогтоосон үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах;

2.1.4. Актив хөрөнгийг холбогдох журмын дагуу ангилж, эрсдэлийн сан байгуулах;

2.1.5. Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хөтлөх;

2.1.6. Санхүүгийн тайланг Аудитын тухай хуульд заасны дагуу баталгаажуулах;

2.1.7. Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хугацаанд нь төвлөрүүлэх;

2.1.8. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.1.9. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 46.2-т заасны дагуу санхүүгийн болон зохистой харьцааны тайлан, статистик мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд зохих маягтын дагуу гаргаж Хорооны цахим хуудас дахь “Цахим тайлан” цэсээр болон хэвлэмэл байдлаар Хороонд хүргүүлэх;

2.1.10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу харилцагч/гишүүнийг таньж мэдэх ажиллагааг гүйцэтгэж, эцсийн өмчлөгчийг тогтоох арга хэмжээ авах, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны <https://goaml.mongolbank.mn/> цахим системд бүртгүүлэн сэжигтэй гүйлгээг 24 цагийн дотор, 20 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээний мэдээллийг ажлын 5 хоногийн дотор мэдээлэх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулгыг хагас жил тутам Хороонд цахимаар хүргүүлэх;

2.1.11. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-д заасны дагуу хоршооны үйл ажиллагааны онцлогт нийцсэн “Дотоод хяналтын хөтөлбөр”-ийг боловсруулан бүх гишүүдийн хурлаар батлах, энэхүү хуулийн 14.4.11-т заасны дагуу дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилон, тогтмол хяналт тавьж ажиллах;

2.1.12. Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй мэдээлэл өгөх, авах гэрээг байгуулах, зээлдэгч гишүүдийн мэдээллийг тогтмол нийлүүлэх, зээл олгох бүр мэдээллийн сангаас лавлагаа авч зээлийн эрсдэлээс сэргийлж ажиллах;

2.1.13. Хадгаламж болон зээлийн үйл ажиллагааны бодлогыг бүх гишүүдийн хурлаар батлах, уг бодлогод нийцүүлэн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах хадгаламжийн болон зээлийн үйл ажиллагааны журмыг тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар баталж мөрдүүлэх;

2.1.14. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Хорооноос баталсан журам, заавар, загвар, зөвлөмжийн дагуу холбогдох дотоод журам, заавар, аргачлалыг бүх гишүүдийн хурал болон тэргүүлэгчдийн зөвлөлөөр баталж мөрдөх;

2.1.15. Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал болон салбарын захирал нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34.3, 34.4, 34.11, 36.5, 38.5, 39.6, Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх;

2.1.16. Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал болон салбарын захирал нь сонгогдож, томилогдсоноос хойш 6 сарын хугацаанд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх;

2.1.17. Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, салбарын захирал болон нягтлан бодогч өөрчлөгдсөн бол энэхүү нөхцөл, шаардлагын 5 дугаар хавсралтын дагуу гаргасан өргөдөл, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасан шаардлагыг хангасан болохыг нотлох баримтын хамт ажлын 10 өдрийн дотор **Хорооны цахим хуудас дахь “Зөвшөөрлийн цахим систем”-ээр болон хэвлэмэл байдлаар** Хороонд мэдэгдэх;

2.1.18. ХЗХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах 2-оос доошгүй ажилтан (гүйцэтгэх захирал болон нягтлан бодогч эсхүл гүйцэтгэх албаны бусад ажилтан)-тай байх;

2.1.19. Үйл ажиллагаа явуулах ажлын байр болон салбарын ажлын байр, техник, тоног төхөөрөмж, санхүүгийн программ хангамж нь тухайн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, шаардлагыг хангасан байх;

2.1.20. Үйл ажиллагаа явуулах ажлын байр болон салбарын ажлын байр нь барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулсан байх;

2.1.21. Санхүүгийн бэлэн бус гүйлгээг зөвхөн ХЗХ-ны нэр дээрх арилжааны банкин дахь дансаар хийх;

2.1.22. ХЗХ нь гишүүдийн бүртгэлийг тогтмол хөтлөх ба гишүүдийн дэлгэрэнгүй бүртгэл болон хувь хөрөнгийн өөрчлөлтийн мэдээллийг хагас, бүтэн жилээр Хороонд мэдэгдэх;

2.1.22.1. Гишүүн хувь хүн бол бүртгэлд овог, нэр, регистрийн дугаар, хаяг, холбоо барих утас, оруулсан хувь хөрөнгийн хэмжээ, гишүүнээр элссэн огноо зэрэг мэдээллүүд багтсан байна.

2.1.22.2. Гишүүн хуулийн этгээд бол бүртгэлд хуулийн этгээдийн регистрийн дугаар, хувьцаа эзэмшигчдийн тоо, хувьцаа эзэмшигчийн овог нэр, регистрийн дугаар, оруулсан хувь хөрөнгийн хэмжээ зэрэг мэдээллүүд багтсан байна.

2.1.23. Гишүүдийн оруулж буй хувь хөрөнгө тухайн иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны үйл ажиллагаанаас бий болсон орлого эсэхийг ХЗХ нь тухай бүр нягталдаг байх;

2.1.24. Салбар нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасан гишүүнчлэлийн нөхцөлийг хангасан байх;

2.1.25. ХЗХ нь албан ёсны цахим шуудангийн хаяг /ХЗХ-ны нэрийг тусгасан/-тай байх, өөрчилсөн бол ажлын 5 өдрийн дотор Хороонд мэдэгдэх;

2.1.26. ХЗХ нь оноосон нэрээ өөрчилсөн тохиолдолд энэхүү нөхцөл, шаардлагын 4 дүгээр хавсралтын дагуу гаргасан өргөдөл, бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн шийдвэр, ХЗХ-ны дүрэмд тусгасан шинэчилсэн дүрэм болон бүх гишүүдэд оноосон нэрийн өөрчлөлтийн талаар мэдээлснийг нотлох баримтын хамт ажлын 5 өдрийн дотор **Хорооны цахим хуудас дахь “Зөвшөөрлийн цахим систем”-ээр болон хэвлэмэл байдлаар** Хороонд мэдэгдэх;

2.1.27. Ажлын байрны хаяг байршил өөрчлөгдсөн тохиолдолд энэхүү нөхцөл, шаардлагын 4 дүгээр хавсралтын дагуу гаргасан өргөдөл, бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн шийдвэр, ХЗХ-ны дүрэмд тусгасан шинэчилсэн дүрэм болон бүх гишүүдэд хаяг байршлын өөрчлөлтийн талаар мэдээлснийг нотлох баримтын хамт ажлын 7 өдрийн дотор **Хорооны цахим хуудас дахь “Зөвшөөрлийн цахим систем”-ээр болон хэвлэмэл байдлаар** Хороонд мэдэгдэх;

2.1.28. ХЗХ нь салбар байгуулсан тохиолдолд энэхүү нөхцөл, шаардлагын 4 дүгээр хавсралтын дагуу гаргасан өргөдөл, бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн шийдвэр, ХЗХ-ны дүрэмд тусгасан шинэчилсэн дүрэм болон бүх гишүүдэд салбарын талаар мэдээлснийг нотлох баримтын хамт ажлын 7 өдрийн дотор **Хорооны цахим хуудас дахь “Зөвшөөрлийн цахим систем”-ээр болон хэвлэмэл байдлаар** Хороонд мэдэгдэх.

ГУРАВ. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ТАВИХ НӨХЦӨЛ

3.1. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн этгээд нь Зөвшөөрлийн тухай хууль болон Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасны дагуу доор дурдсан баримт бичгийг бүрдүүлж Хорооны **цахим хуудас дахь “Зөвшөөрлийн цахим систем”-ээр болон хэвлэмэл байдлаар** Хороонд ирүүлнэ.

3.1.1. Зөвшөөрөл хүссэн албан бичиг;

3.1.2. Энэхүү нөхцөл, шаардлагын 1 дүгээр хавсралтын дагуу гаргасан зөвшөөрөл хүссэн өргөдөл;

3.1.3. Үүсгэн байгуулагчдын хурлын тэмдэглэл, шийдвэр /үүсгэн байгуулагчдын ирцийн бүртгэлийг хуралд оролцсон гишүүдийн гарын үсгээр баталгаажуулсан байх/;

3.1.4. Үүсгэн байгуулагчдын хурлаас Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нийцүүлэн баталсан ХЗХ-ны дүрэм, хадгаламжийн болон зээлийн бодлого, тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны ажиллах журам, уг дүрэм, журмыг баталсан хурлын тэмдэглэл, шийдвэр;

3.1.5. Тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар баталсан хадгаламжийн болон зээлийн үйл ажиллагааны журам, журмыг баталсан хурлын тэмдэглэл, шийдвэр;

3.1.6. Гишүүдийн оруулж буй хувь хөрөнгө нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан, хууль ёсны үйл ажиллагаанаас бий болсон орлого болохыг нотлох баримт, тайлбар тодруулгыг ирүүлэх ба уг мөнгөн хөрөнгийг ХЗХ-ны банкин дахь харилцах дансанд байршуулах;

3.1.7. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34, 36 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн томилсон тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга, гишүүд, хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилсон тухай бүх гишүүдийн хурлын тэмдэглэл шийдвэр, эдгээр албан тушаалтнуудын энэхүү нөхцөл, шаардлагын 2 дугаар хавсралтын дагуу гаргасан анкет;

3.1.8. ХЗХ-ны үүсгэн байгуулагч гишүүн бүр Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгыг бүрэн гүйцэт, үнэн зөв гаргах;

3.1.9. ХЗХ-ны сонгуульт гишүүд, гүйцэтгэх захирал болон 20 сая төгрөг, түүнээс дээш оруулсан хувь хөрөнгө бүхий гишүүд эцсийн өмчлөгчийг тодорхойлох асуулгыг бүрэн гүйцэт, үнэн зөв гаргах;

3.1.10. Энэхүү нөхцөл, шаардлагын 3 дугаар хавсралтын дагуу бэлтгэсэн санхүүгийн эхлэлтийн тайлан тэнцэл;

3.1.11. Бүх гишүүдийн хурлаар баталсан 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөө;

3.1.12. Шаардлагатай тохиолдолд тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга, гишүүн, хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, зээлийн хорооны дарга, гишүүн, гүйцэтгэх захирлын орон нутгийн хөгжил, хоршооны талаар мэдлэг, туршлагатайг нотлох тодорхойлолт;

3.1.13. Гүйцэтгэх захирлыг томилсон тухай тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, тэргүүлэгчдийн зөвлөлийн даргатай байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон энэхүү нөхцөл, шаардлагын 2 дугаар хавсралтын дагуу гаргасан анкет;

3.1.14. Нягтлан бодогчийг томилсон тухай гүйцэтгэх захирлын тушаал, гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээ болон энэхүү нөхцөл, шаардлагын 2 дугаар хавсралтын дагуу гаргасан анкет;

3.1.15. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах “Дотоод хяналтын хөтөлбөр”, дотооддоо мөрдөх журмыг бүх гишүүдийн хурлаар баталсан тэмдэглэл, шийдвэр, тус дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилсон гүйцэтгэх захирлын тушаал;

3.1.16. Үйл ажиллагаа явуулах ажлын байр нь түрээсийн бол түрээсийн гэрээ, өөрийн өмчлөлийн бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар.

ДӨРӨВ. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт заасны дагуу Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан хадгаламж, зээлийн хоршоодын холбоо “Үндэсний холбоо” гэх тодотголыг оноосон нэрд хэрэглэнэ.

4.2. Үндэсний холбоо нь дараах шаардлагыг хангасан байна:

4.2.1. Үндэсний холбоо нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн, оноосон нэр, тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас, харилцах данстай байх;

4.2.2. Үндэсний холбооны үйл ажиллагаа нь хоршооллын мөн чанарт түшиглэсэн, хадгаламж, зээлийн хоршооны олон улсын зарчимд нийцсэн байх бөгөөд эдгээрийг дүрэмдээ тусгасан байх;

4.2.3. Үндэсний холбоо нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нийт хадгаламж, зээлийн хоршоодын 50-иас доошгүй хувийг гишүүнээр элсүүлсэн байх;

4.2.4. Хадгаламж, зээлийн хоршоодын холбоо нь үүсгэн байгуулагдсанаас хойш 2-оос доошгүй жилийн хугацаанд үйл ажиллагаагаа тогтмол явуулж, туршлага хуримтлуулсан байх;

4.2.5. Монголын хоршооллын хөдөлгөөнийг дэмжин “Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо”-нд гишүүнээр элсэн хамтран ажилладаг байх;

4.2.6. Олон улсын болон бүсийн түвшний ижил төрлийн зорилго бүхий байгууллагуудтай түншлэлийн харилцаа тогтоож, хамтын ажиллагааг хөгжүүлж чадсан, тэдгээрт гишүүнчлэлтэй байх;

4.2.7. Хадгаламж, зээлийн хоршооны салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө боловруулсан, хадгаламж, зээлийн хоршоодод мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, техник хэрэгслийн болон боловсон хүчний чадавхтай байх;

4.2.8. Үндэсний холбоо нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасан бүтэц, зохион байгуулалттай, чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх.

4.3. Үндэсний холбоонд тавигдах шаардлага хангагдсан болохыг Хорооны шийдвэрээр тодорхойлж, Хадгаламж, зээлийн хоршооны тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллана.

ТАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

5.1. ХЗХ-ны үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, нөхцөл, шаардлагад нийцэж байгаа эсэхэд Хороо хяналт тавьж, зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он	Сар	Өдөр
Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байсан эсэх			Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>
Тийм бол хаана, ямар үйл ажиллагааг, ямар хугацаагаар эрхэлсэн талаар бичих			
Өмнө нь тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлж байсан эсэх			Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>
Тийм бол хэзээ ирүүлсэн, хэрхэн шийдвэрлэсэн талаар бичих			
I. ХЗХ-ны ерөнхий мэдээлэл			
ХЗХ-ны нэр:	Монгол		
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичих)		
Оноосон нэрд орсон өөрчлөлт /хэрэв өөрчлөгдөж байсан бол/	Нэр _____		
	Хэзээнээс ____ / ____ / ____ хүртэл ____ / ____ / ____ (Оноосон нэр өөрчлөгдсөн бол өмнөх нэрийг бүтэн бичиж, хэзээнээс хэдий хүртэл тухайн нэрийг хэрэглэсэн талаарх хугацааг он/сар/өдөр дарааллаар бичих)		
Үүсгэн байгуулагдсан огноо	____ /он/ ____ /сар/ ____ /өдөр/ (Хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан хурлын огноог бичих)		
Улсын бүртгэлийн дугаар			
Регистрийн дугаар			
ХЗХ-ны гишүүдийн тоо			
Гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгө /төгрөг/			
Харилцах <input type="checkbox"/>	Банкны нэр		
	Дансны дугаар		
	Үлдэгдэл /төгрөг /		
Хадгаламж <input type="checkbox"/>	Банкны нэр		
	Дансны дугаар		
	Үлдэгдэл /төгрөг/		
Хаяг байршил:	Аймаг/ хот		
	Сум/дүүрэг		
	Баг/хороо		
	Гудамж, байр		
	Тоот		
Холбоо барих утас:	Суурин	Гар утас	Факс
Цахим хуудас:			
Цахим шуудан:			

ХЗХ-ны гишүүнчлэлийн хамрах хүрээ (Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан дараах нөхцөлүүдээс тохирохыг сонгож “√” тэмдгийг тавих)

- Нэг байгууллагад ажилладаг
 Үйл ажиллагааны чиглэл адил нийгэмлэг, холбоонд гишүүнчлэлтэй
 Нэг сум/ хорооны харьяалалтай
 Нэг дүүрэгт харьяалалтай
 Нэг хот/ аймгийн харьяалалтай

II. Үүсгэн байгуулагч гишүүдийн мэдээлэл (Овог, нэр, регистрийн дугаарыг үнэн зөв, гаргацтай, бүтнээр бичиж, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны дэлгэрэнгүй хаяг, хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийн дүнг бичих)

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Оршин суух хаяг, холбоо барих утас	Хувь нийлүүлсэн хөрөнгө /төгрөг/
1				
2				
3				
4				
5				
...				

Тэмдэглэл: Үүсгэн байгуулагч гишүүн бүрийг жагсаан бичих

III. Сонгуульт болон гүйцэтгэх удирдлагын мэдээлэл

а/ Тэргүүлэгчдийн зөвлөлийн бүрэлдэхүүн

№	Овог, нэр	Дарга / гишүүн	Регистрийн дугаар	Ажлын хаяг, холбоо барих утас	Боловсролын байдал		
					Төгссөн сургууль	Дипломын дугаар	Мэргэжил
1							
2							
3							
4							
5							
...							

Тэмдэглэл: Зөвлөлийн гишүүн бүрийг бичих

б/ Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн

№	Овог, нэр	Дарга / гишүүн	Регистрийн дугаар	Ажлын хаяг, холбоо барих утас	Боловсролын байдал		
					Төгссөн сургууль	Дипломын дугаар	Мэргэжил
1							
2							
3							
4							
5							
...							

Тэмдэглэл: Зөвлөлийн гишүүн бүрийг бичих

в/ Зээлийн хорооны бүрэлдэхүүн

№	Овог, нэр	Дарга / гишүүн	Регистрийн дугаар	Ажлын хаяг, холбоо барих утас	Боловсролын байдал		
					Төгссөн сургууль	Дипломын дугаар	Мэргэжил
1							
2							
3							
4							
5							

...							
<i>Тэмдэглэл: Хорооны гишүүн бүрийг бичих</i>							
г/ Гүйцэтгэх албаны бүрэлдэхүүн							
№	Албан тушаал	Овог, нэр	Регистрийн дугаар	Оршин суух хаяг, холбоо барих утас	Боловсролын байдал		
					Төгссөн сургууль	Дипломын дугаар	Мэргэжил
1							
2							
3							
...							
<i>Тэмдэглэл: Албан тушаалтан бүрийг бичих</i>							
IV. Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл							
<input type="checkbox"/> Худалдаж авсан <input type="checkbox"/> Түрээсэлсэн <input type="checkbox"/> Ажлын байрны гаднах талбайн аюулгүй байдлыг хангасан эсэх <input type="checkbox"/> Бусад /тохирохыг сонгож “√” тэмдгийг тавих./							
<i>Тэмдэглэл: үйл ажиллагаа явуулах ажлын байр нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ дэх хаяг байршил, дүрэмд тусгагдсан хаяг байршилтай ижил байх</i>							
V. Ашиглах техник, тоног төхөөрөмжийн мэдээлэл							
№	Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ	
1			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			
2			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			
3			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			
...							
<i>Тэмдэглэл: Техник, тоног төхөөрөмж бүрээр бичих</i>							
VI. Ашиглах программ хангамжийн мэдээлэл							
№	Программ хангамжийн нэр төрөл	Зориулалт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ	
1			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			
2			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			
...							
<i>Тэмдэглэл: Программ хангамж бүрээр бичих</i>							
VII. Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн төлөвлөлт (өссөн дүнгээр)							
Үзүүлэлтүүд			_____ он	_____ он	_____ он		
Эрхлэх үйл ажиллагааны чиглэл							
Нийт хөрөнгө							
Өөрийн хөрөнгө							
Хувь нийлүүлсэн хөрөнгө							
Бусдаас татсан эх үүсвэр							
Нийт орлого							
Нийт зарлага							
Өөрийн хөрөнгийн өгөөж							
Активын өгөөж							
<i>Тэмдэглэл: Бизнес төлөвлөгөөтэй уялдуулан тодорхойлох</i>							

Өргөдөл гаргасан: Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга

Овог, нэр

гарын үсэг

огноо



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ СОНГУУЛТ ГИШҮҮН БОЛОН
ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ

1.Ерөнхий мэдээлэл

Ургийн овог:		3x4 Зураг
Овог:		
Нэр:		
Регистрийн дугаар:		
Иргэний харьяалал:		
ХЗХ-нд эрхлэх сонгуульт болон гүйцэтгэх албан тушаал:		
Оршин суугаа газрын хаяг:		
Гар утасны дугаар:		
Цахим шуудан:		
Эрхэлж байгаа ажил, албан тушаал:		
Ажлын хаяг:		
Цахим шуудан:		

2.Боловсролын байдал /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар
1					
2					
3					
4					
5					

3.Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан
1					
2					
3					
4					

5					
---	--	--	--	--	--

4.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 3.1.4-т заасан “нэгдмэл сонирхолтой этгээд”-ийн мэдээлэл /хадгаламж, зээлийн хоршооны гишүүн, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл болон зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтантай эд хөрөнгө, садан төрлийн зэрэг хувийн ашиг сонирхлын холбоо бүхий этгээд/

№	Ямар хамааралтай болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эрхэлж буй ажил, албан тушаал
1				
2				
3				
4				
5				

Тодорхойлолт гаргасан:

Албан тушаал

Овог, нэр

гарын үсэг

огноо



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ
ЭХЛЭЛТИЙН ТАЙЛАН ТЭНЦЭЛ

Тусгай зөвшөөрөл хүсэгч ХЗХ-ны нэр	
------------------------------------	--

ХӨРӨНГӨ	ДҮН	ӨР ТӨЛБӨР, ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	ДҮН
САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ		ӨР ТӨЛБӨР	
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</i>		<i>Богино хугацаат өр төлбөр</i>	
Бэлэн мөнгө		Дансны өглөг	
Банканд байгаа мөнгө		Урьдчилж орсон орлого	
Бусад санхүүгийн хөрөнгө		Бусад	
Урьдчилж төлсөн зардал		<i>Урт хугацаат өр төлбөр</i>	
		Хойшлогдсон татварын өр төлбөр	
		Бусад урт хугацаат өр төлбөр	
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ		ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	
Дансны авлага		<i>Хувь нийлүүлсэн хөрөнгө</i>	
Үндсэн хөрөнгө		Нэмж тологдсон капитал	
Биет бус хөрөнгө		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	
Бусад санхүүгийн бус хөрөнгө		Тусгай зориулалтын нөөцийн сангууд	
		Хуримтлагдсан ашиг/алдагдал	
Нийт хөрөнгийн дүн		Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө	

Гүйцэтгэх захирал

Гарын үсэг

Огноо

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ОНООСОН НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТ, САЛБАР БАЙГУУЛАХ
БОЛОН ХАЯГ БАЙРШЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХ МАЯГТ

Мэдэгдэл ирүүлсэн огноо	Он	Сар	Өдөр
ХЗХ-ны нэр			
Регистрийн дугаар			
Өөрчлөлтийн талаар мэдээллийн төрлийг сонгох (тохирох нүдэнд “√” тэмдгийг тавих)			
<input type="checkbox"/> 1. Оноосон нэрийн өөрчлөлтийн талаар мэдээлэл <input type="checkbox"/> 2. Салбар байгуулсан талаар мэдээлэл <input type="checkbox"/> 3. Хаяг, байршлын өөрчлөлтийн талаар мэдээлэл			
1. Оноосон нэрийн өөрчлөлтийн талаар			
Оноосон нэр өөрчлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар	_____ /он/ _____ /сар/ _____ /өдөр/		
	Шийдвэрийн хуулбар, хурлын тэмдэглэлийг ирүүлсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>		
ХЗХ-ны шинэ нэр	Нэр _____ (Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас авсан шинэ нэрийн баталгаажуулалтын хуудаст тусгагдсан нэрийг бичих)		
ХЗХ-ны дүрэмд тусган шинэчилсэн дүрмийг ирүүлсэн эсэх	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>		
Бүх гишүүдэд оноосон нэрийн өөрчлөлтийг мэдээлсэн эсэх	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>		
	Бүх гишүүдэд оноосон нэрийн өөрчлөлтийг мэдээлсэн талаар нотлох баримтыг хавсаргасан эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>		
1. Салбар байгуулсан талаар мэдээлэл			
Салбар байгуулах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар	_____ /он/ _____ /сар/ _____ /өдөр/		
	Шийдвэрийн хуулбар, хурлын тэмдэглэлийг ирүүлсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>		
Салбарын хаяг байршил	Аймаг/хот		
	Сум/дүүрэг		
	Баг/Хороо		
	Гудамж, байр		
	Тоот		
	Цахим шуудан		
	Холбоо барих утас		
ХЗХ-ны дүрэмд тусган шинэчилсэн дүрмийг ирүүлсэн эсэх	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>		
Бүх гишүүдэд салбар байгуулсан талаар мэдээлсэн эсэх	Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>		
	Бүх гишүүдэд салбар байгуулсан талаар мэдээлсэн эсэхийг нотлох баримтыг ирүүлсэн эсэх		

		Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>					
Салбарын боловсон хүчний мэдээлэл (<i>Овог, нэр, регистрийн дугаарыг үнэн зөв, гаргацтай, бүтнээр бичиж, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны дэлгэрэнгүй хаяг, боловсролын байдлыг бичих</i>)							
№	Албан тушаал	Овог, нэр	Регистрийн дугаар	Оршин суух хаяг, холбоо барих утас	Боловсролын байдал		
					Төгссөн сургууль	Дипломын дугаар	Мэргэжил
1							
2							
3							
...							
<i>Тэмдэглэл: Албан тушаалтан бүрийг жагсаан бичих</i>							
Салбарын захирал нь энэхүү шаардлагыг байгаа эсэх		Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>		Салбарын захирал нь энэхүү нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэх			
Үйл ажиллагаа ажлын байрны мэдээлэл		Худалдаж авсан <input type="checkbox"/> Түрээсэлсэн <input type="checkbox"/>		Нотлох баримтыг ирүүлсэн эсэх			
		Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>					
Салбарт ашиглах техник, тоног төхөөрөмжийн мэдээлэл							
№	Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ	
1			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			
2			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			
..							
.							
<i>Тэмдэглэл: Техник, тоног төхөөрөмж бүрээр бичих</i>							
Салбарт ашиглах программ хангамжийн мэдээлэл							
№	Программ хангамжийн нэр төрөл	Зориулалт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ	
1			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			
2			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			
..							
<i>Тэмдэглэл: Программ хангамж бүрээр бичих</i>							
2. Хаяг, байршлын өөрчлөлтийн талаар мэдээлэл							
Хаяг, байршлыг өөрчлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар		_____			_____		
		/он/		/сар/		/өдөр/	
		Шийдвэрийн хуулбар, хурлын тэмдэглэлийг ирүүлсэн эсэх					
		Тийм <input type="checkbox"/>		Үгүй <input type="checkbox"/>			
Хаяг байршил		Аймаг/хот					
		Сум/дүүрэг					
		Баг/Хороо					

	Гудамж, байр	
	Тоот	
	Цахим шуудан	
	Холбоо барих утас	
<i>Тэмдэглэл: ХЗХ-ны шинэ хаяг, байршил нь тухайн хоршооны дүрэмд тусгагдсан байх</i>		
ХЗХ-ны дүрэмд тусган шинэчилсэн дүрмийг ирүүлсэн эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Бүх гишүүдэд хаяг, байршлын өөрчлөлтийг мэдээлсэн эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Бүх гишүүдэд хаяг, байршлын өөрчлөлтийг мэдээлсэн талаар нотлох баримтыг ирүүлсэн эсэх	
	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

Мэдэгдэл хүргүүлсэн: Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга

Овог, нэр

гарын үсэг

огноо

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа
эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ын
тавдугаар хавсралт

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ СОНГУУЛЬТ ГИШҮҮД БОЛОН ГҮЙЦЭТГЭХ АЛБАН
ТУШААЛТНЫ ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХ МАЯГТ

Мэдэгдэл ирүүлсэн огноо	Он		Сар		Өдөр			
ХЗХ-ны нэр								
Регистрийн дугаар								
Өөрчлөлтийн талаар мэдээллийн төрлийг сонгох (тохирох нүдэнд “√” тэмдгийг тавих)								
<input type="checkbox"/> Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүн <input type="checkbox"/> Хяналтын зөвлөлийн гишүүн <input type="checkbox"/> Зээлийн хорооны гишүүн <input type="checkbox"/> Гүйцэтгэх захирал <input type="checkbox"/> Салбарын захирал								
1. Шинэ сонгуульт гишүүдийн мэдээлэл								
Сонгуульт гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар		_____ /он/		_____ /сар/		_____ /өдөр/		
		Шийдвэрийн хуулбар, хурлын тэмдэглэлийг ирүүлсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>						
Гүйцэтгэх захирал, салбарын захирлыг томилсон тэргүүлэгчдийн зөвлөлийн шийдвэрийн огноо дугаар		_____ /он/		_____ /сар/		_____ /өдөр/		
		Шийдвэрийн хуулбар, хурлын тэмдэглэл болон гүйцэтгэх захирал, салбарын захиралтай байгуулсан гэрээг ирүүлсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>						
<i>(Овог, нэр, регистрийн дугаарыг үнэн зөв, гаргацтай, бүтнээр бичиж, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны дэлгэрэнгүй хаяг, боловсролын байдлыг бичих)</i>								
№	Албан тушаал	Сонгосон/ томилсон шийдвэрийн огноо	Овог, нэр	Регистрийн дугаар	Оршин суух хаяг, холбоо барих утас	Боловсролын байдал		
						Төгссөн сургууль	Дипломын дугаар	Мэргэжил
1								
2								
3								
...								
<i>Тэмдэглэл: Албан тушаалтан бүрийг жагсаан бичих</i>								
Сонгуульт гишүүд, гүйцэтгэх захирал, салбарын захирал нь энэхүү шаардлагыг хангаж байгаа эсэх		Тийм <input type="checkbox"/>		Үгүй <input type="checkbox"/>				
Тохиромжтой тодорхойлох асуулгыг ирүүлсэн эсэх		Тийм <input type="checkbox"/>		Үгүй <input type="checkbox"/>		Журмын 2 дугаар хавсралтын дагуу хадгаламж, зээлийн хоршооны сонгуульт гишүүн болон гүйцэтгэх албан тушаалтны анкетыг ирүүлсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>		

Мэдэгдэл хүргүүлсэн: Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга

Овог, нэр

гарын үсэг

огноо